

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАМЫН-ҮҮД ХОТЫН
ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБА**

**ЕРӨНХИЙ БОЛОВСОРЛЫН 1 ДҮГЭЭР СУРГУУЛИЙН
ДОТУУР БАЙРНЫ ХҮҮХДИЙН ХООЛ, ХҮНС
НИЙЛҮҮЛЭХ ТЕНДЕРИЙН БИЧИГ БАРИМТ**

Тендер шалгаруулалтын нэр : Ерөнхий боловсорлын 1 дүгээр сургуулийн
Дотуур байрны хүүхдийн хоол, хүнс нийлүүлэх

Гэрээний нэр, дугаар: ***ТБ-Б/39/2020***

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Тендер зарлах өдөр: 2020.03.08

Дорноговь аймгийн Замын-Үүд Хотын захирагчийн ажлын алба нь эрх бүхий тендерт оролцогчдоос “Ерөнхий боловсорлын 1 дүгээр сургуулийн Дотуур байрны хүүхдийн хоол, хүнс нийлүүлэх” цахим тендерт үнийн санал ирүүлэхийг урьж байна.

БАГЦ-01 Хүнсний ногоо- 3 015 000 төгрөг

БАГЦ-02 Лазалсан бүтээгдэхүүн-795 500 төгрөг

БАГЦ-03 Бусад хүнсний бүтээгдэхүүн-1 682 240 төгрөг

БАГЦ-04 Талх, нарийн боов-786 500 төгрөг

БАГЦ-05 Гурил, будаа сахар, гоймон- 3186 300 төгрөг

Үнийн санал ирүүлэх техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн санал ирүүлэх ажлын тоо хэмжээ, техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Тендерийн баримт бичгийг эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдлээр нь 50 000 төгрөгөөр худалдан авна. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 30 хоногийн дотор хүчинтэй байна Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 30 хоногийн дотор хүчинтэй байна.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан 2020 оны 03-р сарын 31-ний өдрийн 09 цаг 00 минутад нээнэ.

Тендерийн материалыг 2020 оны 03-р сарын 31-ний өдрийн 09 цаг 30 минутаас өмнө www.tender.gov.mn цахим хуудсаар ирүүлнэ.

Дотоодын давуу эрх тооцохгүй

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Дорноговь аймаг Замын-Үүд сум Сүлд баг
Нутгийн удирдлагын ордон 2 давхар 17 тоот Утас: 70527500

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- | | |
|---|--|
| 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа | 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна. |
| 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт | 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ. |
| 3. Тендерийн иж бүрдэл | 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:

(а) Үнийн санал;
(б) Үнийн боло нийлүүлэлтийн хуваарь;
(в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
(г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
(д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.] |
| 4. Тогтмол үнэ | 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд |

тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.

- | | |
|---|---|
| 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд | 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана. |
| | 5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ. |
| 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа | 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна. |
| 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх | 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ. |
| | 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь ТШӨХ-д заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ. |
| | 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно. |
| 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл | 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна. |

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<p>- Сүүлийн 1 жилийн санхүүгийн тайлан аудитын дүгнэлтийн хамт ирүүлэх</p> <p>- Сүүлийн 1 жилийн туршлагын мэдээллийг нотлох баримтын хамт ирүүлэх / гэрээ, хүлээн авсан акт, гэрээ дүгнэсэн протокол/</p> <p>- Улсын бүртгэлийн гэрчилгээний баталгаажсан хуулбар</p> <p>- Тендерт оролцогчийг төлөөлж гарын үсэг зурсан этгээдийн итгэмжлэл</p> <p>- Харилцагч банкны тодорхойлолт /өргүй байх/ Эх хувь хуулбарласан тохиолдолд нотариотоор батлуулсан байх</p> <p>- Татварын газрын тодорхойлолт/өргүй байх/ Эх хувь хуулбарласан тохиолдолд нотариотоор батлуулсан байх</p> <p>- Нийгмийн даатгалын газрын тодорхойлолт /өргүй байх/ Эх хувь хуулбарласан тохиолдолд нотариотоор батлуулсан байх</p> <p>- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт /өргүй байх/ Эх хувь хуулбарласан тохиолдолд нотариотоор батлуулсан байх</p> <p>-Шүүхийн тодорхойлолт. Эх хувь хуулбарласан тохиолдолд нотариотоор батлуулсан байх</p> <p>-Түргэн хөрвөх чадвартай хөрөнгийн хэмжээ төсөвт өртөгийн 50%-иас дээш</p> <p>- Нийлүүлэх барааны үнийн санал, бараа нийлүүлэлтийн хуваарийг маягтын дагуу баталгаажуулан ирүүлэх.</p> <p>- Тендерт шалгарсан тохиолдолд гэрээний үнэ болон хугацаанд багтаан чанарын шаардлага хангасан барааг захиалагчид нийлүүлэх баталгааг албан бичгээр гаргаж ирүүлнэ,</p> <p>Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөл Үүнд: Шаардлагатай</p> <p>/ хүчинтэй хугацаа дуусаагүй байх , хүчинтэй хугацаа дуусч эрх бүхий байгууллагад хүсэлт гарган шийдвэрлэх явцад байгаа зөвшөөрлийг хүчинтэйд тооцож хүлээн авахгүй /</p> <p>Тендерт оролцогч нь гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй ашиглагдах</p>

	<p>шаардлагатай дараах үндсэн машин механизм, тоног төхөөрөмжтэй байх: шаардлагагүй</p> <p>Тендерт оролцогч нь гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй ашиглагдах шаардлагатай дараах үндсэн машин механизм, тоног төхөөрөмжтэй байх шаардлагагүй</p>
--	---

<p>ТӨӨЗ 2.1</p>	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Тендер хүлээн авах этгээд: tender.gov.mn цахим сайтаар</p> <p>Байгууллагын хаяг: Дорноговь аймаг Замын-Үүд сум, Сүлд баг , Нутгийн удирдлагын ордон Давхар болон өрөөний дугаар: 1 давхар 17 тоот</p> <p>Огноо: 2020 оны 03-р сарын 31-ний өдрийн 09 цаг 00</p> <p>Тендерийн хүлээн авах хийх газар, хугацаа нь:</p> <p>Байшин, гудамжны нэр: Монгол Улс Дорноговь аймаг Замын-Үүд сум, Сүлд</p>
<p>ТӨӨЗ 2.1</p>	<p>Т Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Дорноговь аймаг Замын-Үүд сум, Сүлд баг , Нутгийн удирдлагын ордон Давхар болон өрөөний дугаар: 1 давхар 17 тоот</p> <p>Тендерийн нээлт хийх огноо, цаг нь: Огноо: 2020 оны 03-р сарын 31-ний өдрийн 09 цаг 30</p>
<p>ТӨӨЗ 2.3</p>	<p>Дөрөвдүгээр бүлгийн маягтуудаас гадна эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох дараах баримт бичиг, материалыг өөрийн тендертээ нууцлахгүй ирүүлнэ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Сүүлийн 1 жилийн санхүүгийн тайлан аудитын дүгнэлтийн хамт ирүүлэх - Сүүлийн 1 жилийн туршлагын мэдээллийг нотлох баримтын хамт ирүүлэх / гэрээ, хүлээн авсан акт, гэрээ дүгнэсэн протокол/ - Улсын бүртгэлийн гэрчилгээний баталгаажсан хуулбар - Тендерт оролцогчийг төлөөлж гарын үсэг зурсан этгээдийн итгэмжлэл - Харилцагч банкны тодорхойлолт /өргүй байх/ Эх хувь хуулбарласан тохиолдолд нотариотоор батлуулсан байх - Татварын газрын тодорхойлолт/өргүй байх/ Эх хувь хуулбарласан тохиолдолд нотариотоор батлуулсан байх - Нийгмийн даатгалын газрын тодорхойлолт /өргүй байх/ Эх хувь хуулбарласан тохиолдолд нотариотоор батлуулсан байх - Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт /өргүй байх/ Эх хувь хуулбарласан тохиолдолд нотариотоор

	<p>батлуулсан байх</p> <p>-Шүүхийн тодорхойлолт. Эх хувь хуулбарласан тохиолдолд нотариотоор батлуулсан байх</p> <p>-Түргэн хөрвөх чадвартай хөрөнгийн хэмжээ төсөвт өртөгийн 50%-иас дээш</p> <p>- Нийлүүлэх барааны үнийн санал, бараа нийлүүлэлтийн хуваарийг маягтын дагуу баталгаажуулан ирүүлэх.</p> <p>- Тендерт шалгарсан тохиолдолд гэрээний үнэ болон хугацаанд багтаан чанарын шаардлага хангасан барааг захиалагчид нийлүүлэх баталгааг албан бичгээр гаргаж ирүүлнэ,</p> <p>- Оролцогч албан ёсны цахим хаяг болон байгууллагын хаяг, утасны дугаарыг бичиж ирүүлэх</p> <p>Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөл Үүнд: Шаарлагатай / хүчинтэй хугацаа дуусаагүй байх , хүчинтэй хугацаа дуусч эрх бүхий байгууллагад хүсэлт гарган шийдвэрлэх явцад байгаа зөвшөөрлийг хүчинтэйд тооцож хүлээн авахгүй /</p> <p>Тендерт оролцогч нь гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй ашиглагдах шаардлагатай дараах үндсэн машин механизм, тоног төхөөрөмжтэй байх: шаардлагагүй</p> <p>1. Тендерт оролцогч нь гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй ашиглагдах шаардлагатай дараах үндсэн машин механизм, тоног төхөөрөмжтэй байх шаардлагагүй</p>
<p>ТӨӨЗ 6.2</p>	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ:</p> <p>БАГЦ-01 Хүнсний ногоо- 3 015 000 төгрөг</p> <p>БАГЦ-02 Лазалсан бүтээгдэхүүн-795 500 төгрөг</p> <p>БАГЦ-03 Бусад хүнсний бүтээгдэхүүн-1 682 240 төгрөг</p> <p>БАГЦ-04 Талх, нарийн боов-786 500 төгрөг</p> <p>БАГЦ-05 Гурил, будаа сахар, гоймон- 3186 300 төгрөг</p>

Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

№	Төрөл	Бүтээгдэхүүний нэр	Х.Нэгж	Тоо	Шинж чанар
1	Багц -01 Хүнсний ногоо	Байцаа	кг	360	MNS 4377;96 чанарын шаардлага хангасан,нитрат 1500мг/ кг-аас ихгүй,перметин агуулаагүй,хатаж хорчийгоогүй шинэ гадны мэдэгдэх үнэргүй хогт хольцгүй хэлбэр дүрсээ алдаагүй монголд тариалсан байх /шинжилгээний бичиг дагалдаж байх
2		Лууван	кг	300	MNS 4377;96 чанарын шаардлага хангасан,нитрат 1500мг/ кг-аас ихгүй,перметин агуулаагүй,хатаж хорчийгоогүй шинэ гадны мэдэгдэх үнэргүй хогт хольцгүй хэлбэр дүрсээ алдаагүй монголд тариалсан байх /шинжилгээний бичиг дагалдаж байх
3		Шар манжин	кг	200	MNS 4377;96 чанарын шаардлага хангасан,нитрат 1500мг/ кг-аас ихгүй,перметин агуулаагүй,хатаж хорчийгоогүй шинэ гадны мэдэгдэх үнэргүй хогт хольцгүй хэлбэр дүрсээ алдаагүй монголд тариалсан байх /шинжилгээний бичиг дагалдаж байх
4		Сонгино	кг	250	MNS 4377;96 чанарын шаардлага хангасан,нитрат 250мг/ кг-аас ихгүй,перметин агуулаагүй,хатаж хорчийгоогүй шинэ гадны мэдэгдэх үнэргүй хогт хольцгүй хэлбэр дүрсээ алдаагүй монголд тариалсан байх /шинжилгээний бичиг дагалдаж байх
5		Төмс	кг	900	MNS 4377;96 чанарын шаардлага хангасан,нитрат 250мг/ кг-аас ихгүй,перметин агуулаагүй,хатаж хорчийгоогүй шинэ гадны мэдэгдэх үнэргүй хогт хольцгүй хэлбэр дүрсээ алдаагүй монголд тариалсан байх /шинжилгээний бичиг дагалдаж байх

6		Чинжүү	кг	50	MNS 4377;96 чанарын шаардлага хангасан,нитрат 60мг/кг-аас ихгүй ,гадны мэдэгдэх үнэргүй, хогт хольцгүй хэлбэр дүрсээ алдаагүй,монголд тариалсан байх./шинжилгээний бичиг дагалдаж байх
07	Багц-02 Лазалсан бүтээгдэхүүн	Варень	ш	10	MNS 4833;1975 шаардлага хангасан,бичил биетний ерөнхий тоо 1гр-д 5*10,salmonaila ssp, E coli,спортой савханцар агуулаагүй, монгол жимсний варень байх.
08		Варень	ш	15	
09		Варень	ш	15	
10		Алаг салат	ш	15	Орц: Лууван, цэвэршүүлсэн ус, сонгино, амтат чинжүү, улаан лоолийн нухаш, өргөст хэмх, ургамлын тос, элсэн чихэр, давс, сармис. Тэжээллэг чанар: Илчлэг-254 ккал, Нүүрс ус-18.24%, Чихэрлэг-7.16%, Давс-1.37%, Уураг-6.44%, Тослог-1.7%
11	Багц-02 Лазалсан бүтээгдэхүүн	Өөг салад	ш	30	Орц: Лууван, цэвэршүүлсэн ус, сонгино, амтат чинжүү, улаан лоолийн нухаш, өргөст хэмх, ургамлын тос, элсэн чихэр, давс, сармис. Тэжээллэг чанар: Илчлэг-429.5 ккал, Нүүрс ус-21.75%, Чихэрлэг-8.96%, Давс-1.77%, Уураг-9.66%, Тослог-4.8%
12		Личо амтлагч	ш	20	Орц: Лууван, цэвэршүүлсэн ус, сонгино, амтат чинжүү, улаан лоолийн нухаш, өргөст хэмх, ургамлын тос, элсэн чихэр, давс, перец. Тэжээллэг чанар: Илчлэг-344.1 ккал, Нүүрс ус-13.98%, Чихэрлэг-6.76%, Давс-1.54%, Уураг-0.8%, Тослог-3.3%
13		Молоко	ш	40	Тэжээллэг чанар: Илчлэг чанар 130 ккал, Өөх тосны илчлэг: 40 ккал, Ураг -2%, нийт нүүрс ус-8%, Витамин-А-5%,В1-23%, Д3-12%, Калци-3%
14		Шокладны крем	ш	30	600 гр, Нийт илчлэг-2420 ккал
15	Багц-03 Бусад хүнсний бүтээгдэхүүн	Үзэм	кг	84	MNS 5132;2002,MNS ISO 6579;1999 чанарын шаардлага хангасан,шинжилгээгээр хөгц мөөгөнцөр, salmonella илрээгүй байх.
16		Майноз	ш	10	Орц: Ургамлын тос, уураг, сахар, давс, гич E-160, Цагаан цуу, хүнсний тогтворжуулагч E-415

17		Хоол амтлагч	ш	60	Орц: Давс, амт үнэр нэмэгч, натрий глутамал, жижиглэн хэрчсэн сонгино, сармис, буудайн гурил, гоньд, яншуй, цагаан гаа, үсүү, хар перец
18		Давс	кг	20	Иоджуулсан монгол бор давс байх
19		Далайн байцаа	ш	20	Иодын хэмжээ 0.1%-0.13%,илчлэг 20ккал, нүүрс ус 0.5%,өөх тос 1%, уураг 1%-иас багагүй байна.
20		Масло	кг	50	
21		Ургамалын тос	ш	85	MNS 6646;2016 чанарын шаардлага хангасан, чийг дэгдэмхий бодис 0.1%-иас ихгүй, хүчлийн тоо 0.3 мг КОН/гр -иас ихгүй, саванжилтын тоо 194-240мг КОН/г тос,хэт исэл 2.0-10.0%-иас ихгүй байх.
22		Хөөлгөгч	ш	30	MNS(CAC)4293;1995 стандарттай дүйцэхүйц эрүүл ахуй,аюулгүй байдлын шинжилгээнд борэн хамруулсан байна.
23		Цайны идээ /Их тайлга/	ш	20	Хөгц мөөгөнцөр 10, хар тугалга 10.0мг-аас ихгүй,кадьми 1.0мг- аас ихгүй чийглэг 8.0%-аас ихгүй, танин 1.0%-аас багагүй,хандлагдах 15.0% -иас багагүй ,бактери,И,коли
24		Талх	ш	200	жин-850гр механик гэмтэлгүй жигд цайвар шаргал өнгөтэй хөөлт сайтай гүйцэд бололттой өөрийн нэр төрөлдөө тохирсон амт үнэртэй байх нийлэг уутанд савласан байх хадгалах хугацаа үйлвэрлэсэн он сар өдөр байх
25		Багц-04 Талх, нарийн боов	Цайны боов	кг	30
26		Маюур	кг	30	: Мушгиа гонзгой хэлбэртэй 450 гр савлагдсан жигд бор шараар хосолсон ,өнгөтэй гүйцэд бололттой өөрийн нэр төрөлдөө тохирсон амт үнэртэй
27		Сүүтэй булочик	кг	10	:мушгираа хэлбэртэй ,450 гр савлагдсан жигд цайвар шаргал өнгөтэй гүйцэд бололттой өөрийн нэр төрөлдөө тохирсон амт үнэртэй
28		Боорцог	кг	15	

29		Цайны печень	кг	60	: Цагариг хэлбэртэй,450гр савлагдсан жигд шаргал өнгөтэй гүйцэд бололттой өөрийн нэр төрөлдөө тохирсон амт үнэртэй
30		Зүсмэл	кг	20	: Дөрвөлжин хэлбэртэй ,зүсэлттэй 800гр савлагдсан жигд цайвар шаргал өнгөтэй гүйцэд бололттой өөрийн нэр төрөлдөө тохирсон амт үнэртэй
31		Савхан боорцог	кг	30	Савхан хэлбэртэй 450 гр савлагдсан жигд бор шараар хосолсон ,өнгөтэй гүйцэд бололттой өөрийн нэр төрөлдөө тохирсон амт үнэртэй
32	Гурил, будаа сахар, гоймон	Алтан тариан гурил	ш	450	MNS 0244-2009 стандартыг хангасан, төмөрлөг 3мг/кг-аас ихгүй, үнслэг 0.75%-иас ихгүй, цавуулаг 30.0%-иас багагүй,хүчиллэг 4.0 Н-иас ихгүй , чийглэг 15.5%-иас ихгүй байх
33		Шар будаа	кг	60	MNS 0533;1998 чанарын шаардлага хангасан,чийглэг 14.0%-иас ихгүй ,гэмтсэн үр 0.5%-иас ихгүй, гадны хогт хольц 0.5%-иас ихгүй, хортон шавьж агуулаагүй байх.
34		Каша	кг	80	MNS 0254;1989 чанарын шаардлага хангасан,чийглэг 15.5%-иас ихгүй, төмөрлөг хольц 3.0мг-аас ихгүй , үнслэг 0.8%-иас ихгүй,шинжилгээгээр хортон шавьж илрээгүй байх
35		Хөц будаа	кг	100	MNS 4515;1997 чанарын шаардлага хангасан,чийглэг 15.0%-иас ихгүй,бүтэн будаа 99.6%-иас багагүй, гадны хогт хольц агуулаагүй,хөц будааны хэвийн үнэр амттай,исгэлэн гашуун зэрэг гадны амтгүй,хөгц зэрэг гадны үнэргүй байх.
36		Цагаан будаа	кг	300	MNS ISO 7301;2000 чанарын шаардлага хангасан, чийглэг, 15.0%-иас ихгүй, гэмтсэн үр 3.0%-иас ихгүй,гадны хогт хольц 0.5%-иас ихгүй, төмөрлөг хольц 3.0 мг-аас ихгүй,амьтны гаралтай хольц агуулагдаагүй байх

37		Алёно будаа /Гурвалжин /	кг	130	MNS 6511;2015 чанарын шаардлага хангасан,чийглэг 14.0%-иас ихгүй, бүтэн будаа 99.2%-иас багагүй, бяцарсан цөм 3.0%-иас ихгүй, амьтны гаралтай хольц агуулаагүй гадны хогт хольц 0.5%-аас ихгүй байх.
38		Лапша Гоймон	ш	80	MNS 2233;1975 шаардлага хангасан , чийглэг 14%-иас ихгүй,хүчиллэг 4.0К-иас ихгүй байх.
39		Лапша Гоймон	ш	49	
40		Лапша Гоймон	ш	100	
41		Лапша Гоймон	кг	30	MNS 2233;1975 шаардлага хангасан , чийглэг 14%-иас ихгүй,хүчиллэг 4.0К-иас ихгүй байх.
42		Ролтон /өндөгтэй гоймон/	кг	20	MNS 2233;1975 шаардлага хангасан , чийглэг 14%-иас ихгүй,хүчиллэг 4.0К-иас ихгүй байх.
43		Өндөгтэй гоймон	кг	50	
44		Элсэн чихэр	ш	100	MNS САС 212;2014 стандартыг хангасан,чийг 0.1%-иас ихгүй,Сахароз 99.7%-иас багагүй,Төмөрлөг хольц 3.0%-иас ихгүй байх.

1. Бараа хүргэх газар: Дорноговь аймгийн Замын-Үүд сумын 1 дүгээр сургууль

2. Бараа нийлүүлэлтийн хуваарь:

БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа

1	2	3	4	5	6	7	8

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

Үнэлгээний хорооны дарга Ц.Саруулсайхан танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

4. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/фак с	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|--|---|
| 1. Шалгах болон турших | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа [тоо] жил байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш [ГТН-д заасан тоо] хоногийн дотор шуурхай хийнэ. |

- 8. Бараа нийлүүлэх хуваарь** 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.
- 9. Алданги оногдуулах** 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.
- 10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах** 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.
- 11. Маргааныг шийдвэрлэх** 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- 1. Шалгах болон турших (ГЕН – 1)**
- 1.1. [Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана.]
- 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)**
- 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
- 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
 - 2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;
 - 3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
 - 4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;
 - 5) барааны гарал үүслийн гэрчилгээ.
- Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
- 3. Баталгаат засвар (ГЕН-5)**
- 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.
- [Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.]
- 4. Төлбөр (ГЕН – 7)**
- 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:

Гэрээний үнийн дүнгийн **[moo]**¹ хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.

- 5. Алданги оногдуулах (ГЕН - 9)²**
- 9.1. Алданги оногдуулах хувь: **[moo]**
- Алдангийн нийт дүн: **[moo]**

¹ Ихэнх тохиолдолд 100 хувь байна. Шаардлагатай бол төлбөрийн хуваарийг өөрчилнө.

² Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ	НИЙЛҮҮЛЭГЧ
_____	_____
(Тамга, тэмдэг)	(Тамга, тэмдэг)
_____	_____
(Гарын үсэг)	(Гарын үсэг)
_____	_____
(Албан тушаал)	(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны ____ сарын _____-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн

³ Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны __ дугаар сарын __-наас _____ оны __ дугаар сарын __-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;

Бусад шаардлагатай баримт бичиг⁴;

Үнийн санал;

Гэрээний тусгай нөхцөл;

Гэрээний ерөнхий нөхцөл;

Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;

Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

⁴ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]